

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5-9

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	5-9
--	-----

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 10 дугаар сарын 28-ны өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 18 цаг 58 минутад Төрийн ордны “Их Засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, П.Батчимэг, Х.Ганхуяг, Б.Мөнхсоёл;
Тасалсан: Ж.Алдаржавхлан, Н.Алтанишагай, Ж.Ганбаатар, Б.Жаргалан,
Ч.Лодойсамбуу, О.Цогтгэрэл, М.Энхцэцэг.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохион байгуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Төрийн бүтээмжийн үндэсний хорооны ажлын албаны дарга С.Тэнгис нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохион байгуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Төрийн бүтээмжийн үндэсний хорооны ажлын албаны дарга С.Тэнгис нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.14-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай “3 дахь дэд заалт” нэмэх:

“3/Хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хууль, эрх зүйн шинэчлэлтийн бэлтгэл ажлыг хийх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц саналаа тайлбарлав.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай “4 дэх дэд заалт” нэмэх:

“4/Барилгын салбарт шинэ инновацлаг бараа материал, угсралтын арга барилыг хурдацтай нэвтрүүлэх зорилгоор хот байгуулалт, зураг төсөл, барилгын ажлын стандарт, норм, дүрмийг боловсронгуй болгох ажлыг барилга байгууламжийн норм, нормативын сангийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц саналаа тайлбарлав.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 18 минут үргэлжилж, 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 19 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их Засаг”
танхим 18 цаг 58 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Сэддорж, Бадамсүрэн, Батболд, Батнайрамдал, Батсүмбэрэл Батиугар, Бямбасүрэн, Жаргалан, Лувсанжамц, Соронзонболд, Ундраа, Найдалаа, Цэнгүүн, Энхтүвшин гишүүд одоогоор хүрэлцэн ирж оролцож байна аа. Х.Баттулга гишүүн гадаад томилолттой, П.Батчимэг гишүүн гадаад томилолттой, Х.Ганхуяг гишүүн гадаад томилолттой, Мөнхсоёл гишүүн гадаад томилолттой байна. Ингээд хуралдааны ирц 56 хувьтай байна.

Хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 56 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 10 сарын 28-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал танилцуулъя.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газар энэ төслийг 2024 оны 8 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд бид хүргүүлнэ ээ.

2.Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргыг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа.

Тэгээд энэ асуудлыг яригдах хүн маань гадаад томилолттой байгаа учраас энэ асуудлыг хэлэлцэх асуудлаас хасъя гэсэн саналтай байгаа.

Ингээд нэг асуудлаар өнөөдөр хуралдах нь. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг танилцуулъя. ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга Саруул, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, ТӨБЗГ-ын Төрийн өмчийн удирдлага, зохион байгуулалтын хэлтсийн дарга Баяр-Эрдэнэ, Төрийн бүтээмжийн үндэсний хорооны ажлын албаны дарга Тэнгис.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг баримтлан хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье ээ. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Мандхай гишүүнээр тасаллаа. Мандхай гишүүний микрофоныг өгье.

М.Мандхай: Би нэг ийм юу асуух гэсэн юм аа? Монгол Улсын компанийн тухай хуульд 75.4 Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн

Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн 3-ны 1-ээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна гэж заасан байдаг тиймээ? Гэтэл зарим компанийн охин компани болох төрийн өмчит компани цөөн тоотой ажилчинтай байгаад байдаг. Гэтэл одоо яг энэ төрийн өмчийн компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 ба түүнээс дээш гишүүнтэй байх вэ гэдэг энэ заалт нь өөрөө цөөн ажилтантай компанийн хувьд ч гэсэн адилхан үйлчлээд байдаг зохицуулалт нь яг адилхан байгаад байдаг аа. Тэгэхээр төрийн өмчийн хуулийн этгээдийн энэхүү зохицуулалтыг уян хатан болгох шаардлага байгаа гэж харж байна. Тэгээд энэнтэй холбоотой бас янз бүрийн нөгөө зохицуулалтуудаа өөрчлөлт сайжруулалт орж байгаа зүйл байгаа юу гэдэг асуултыг асууя.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн 4 номерын микрофоныг нээе.

Ц.Баяр-Эрдэнэ: Төрийн өмчийн боловсролын газар Баяр-Эрдэнэ та бүхэнд энэ оройн мэндийг хүргэе.

Ер нь гишүүний асуусан Компанийн хуульд тодорхой зохицуулалт байгаа. Төрийн өмчит болон ХК 9-өөс доошгүй гишүүнтэй. 3-аас доошгүй нь хараат бус байхаар хараат бус гишүүдийнх нь зохицуулалтыг нарийвчилж тусгасан. ТӨК-уд Компанийн хуулийн нэг тодорхой заалтыг барьдаг. Нэг хувьцаа эзэмшигчтэй бол хувьцаа эзэмшигч бас өөрөө тухайн компанийнхаа дотоод зохион байгуулалтын асуудлыг ишийдээд явдаг ийм зохицуулалт байгаа Компанийн хуулийн. Тэгэхээр ТӨК-уд зарим охин компани нь төслийн нэгж хэлбэртэй тусгай зориулалтын шинжтэй одоо нэг 8, 9 хүний бүрэлдэхүүнтэй ийм компаниуд дээр Төлөөлөн удирдах зөвлөлгүй ажилладаг ийм жишиг бол байгаа. Яг өнөөдрийн бодит байдал дээр бол. Цаашидаа ер нь бол төрийн болон орон нутгийн өмчит энэ компанийн тухай

анхдагч хуульд тусгай зориулалтын компаниудыг Төлөөлөн удирдах зөвлөл нь уян хатан байх ийм зохицуулалт оруулахаар төсөлд туссан байгаа.

Өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудал бол Төсвийн хуультай уялдуулж оруулж ирж байгаа асуудал дотор бол энэ асуудлаар тухайлсан зохицуулалт байхгүй. Дандаа нөгөө ил тод байдлыг хангах чиглэлийн зохицуулалтууд байгаа.

Р.Сэддорж: Би нэг юм асууя. Чуулган дээр асуусан.

Худалдан авалтын мэдээллээ ил тод зарлачихдаг. Гэтэл гуравдагч этгээдтэй гэрээ байгуулах болоход үнэ ханин тохиролцох үед нээлттэй болчихсон учраас танайх тэдээр л хийж байсан шүү дээ гэсэн байдлаар ийм хүндрэл үүсэх үү? Хамаг өмнөх борлуулсан хүний мэдээллээ зарлачихдаг дараа нь үнээ арай ихэсгэх багасгах Монгол Улсын эрх ашигт илүү ашигтай байдлаар тохирох асуудал үүсэхэд өмнө нь ийм байсан гээд ийм асуудал үүсгэх үү? Үүсгэх юм биш биз дээ гэсэн.

Хоёрдугаарт нь их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцлийн мэдээллийг нийтэд ил тод болгохоор тухайн компани дахиад гэрээ хэлцэл байгуулахад сөрөг нөлөө гарахгүй юу. Ер нь Монгол Улсын хувьд энэ ашиг сонирхлын зөрчил гэдэг асуудал хүн ам цөөхөн учраас тодорхойлоход их бэрхшээлтэй байдаг. Тэгээд үнэхээр хууль баримтлаад гэрээ хийчихдэг байхад сонирхлын зөрчил орсон байна гээд асуудал яригдах магадлалтай. Тэгээд энийг юу гэж үзэж байгаа вэ гэдэг ийм асуулт байна аа.

4 номерын микрофоныг өгье.

С.Тэнгис: Төрийн өмчийн хорооны ажлын албаны дарга Тэнгис байна. Гишүүний асуултад хариулахад яах вэ нөгөө Засгийн газраас баримталж байгаа бодлогын хувьд ТӨК-удын реформыг одоо

хийхээр бас нэн тэргүүний зорилтоо болгочихсон байгаа. Үгүй ээ үүнтэй холбогдуулаад төрийн болон орон нутгийн өмч ТӨК-удынхаа хуулийг анхдагч хууль гаргах өөрчлөн найруулах, ажлын хэсэг гаргаад яг одоо бас ажиллаж байгаа. Мөн Засгийн газрын үйл ажиллагааны 2024-өөс 2028 оны мөрийн хөтөлбөр Засгийн газрын 100 хоногийн ажлын даалгавар бүгдэд нь ТӨК-ийн реформыг хийх, нээлттэй ХК болох, бэлтгэл ажлыг хангах гээд тийм үүрэг орчихсон байж байгаа.

Тэгэхээр нэгэнт нээлттэй ХК болох ажиллагаа маань өөрөө төрийн өмчийн энэ 100 орчим компанийн хувьд бол тодорхой цаг хугацаа шаардсан. Мэдээж ашигт ажиллагаа бусад засаглалыг нь сайжруулж байж одоо нөгөө хувьцаа олон нийтэд нээлттэй болох үед үнэ цэн нь өсөж өгөөж нь орж ирэхээр байгаа юм. Үүний бэлтгэл ажлууд болгож одоо хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг мөн төрөөс зохицуулалттай салбарт ажилладаг байгууллагуудын хувьд мөн ТУЗ-тэй компаниудын хувьд бүгдэд нь байдаг энэ хуулиар заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлтсүүдийн мэдээллийг ил байлгахар бол Засгийн газраас оруулж ирж байгаа юм.

Эхний асуултын хувьд бол 2021 оны 12 сарын 17-нд батлагдсан Нийтийн мэдээллийн ил тод бай байдлын тухай хуулиар төрийн байгууллага ТӨК бүгдээрээ энэ худалдан авах ажиллагааны мэдээлэл нь энэ 8 дугаар зүйлд зааснаар бол ил тод байхаар заачихсан байгаа юм. Үүнийг ТӨК дээр тодруулж оруулж ирж байгаа юм.

Р.Сэддорж: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүдээс зарчмын зөрүүтэй санал ирүүлээгүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Гишүүд алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан гишүүдээс зарчмын зөрөөтэй санал ирүүлээгүй байна.

Одоо “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Ажлын хэсэг хэвээрээ.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.14 дэх хэсгийг баримталж зарчмын зөрүүтэй саналаа урьдчилан ирүүлсэн байгаа.

Зарчмын зөрөөтэй саналуудаар санал хураалт явуулж эхэлье ээ.

1. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

1. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь заалтад Доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх.

3. Хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлого хэрэгжүүлэхэд

шаардагдах хууль эрх зүйн шинэчлэлтийн бэлтгэл ажлыг хийх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц саналаа тайлбарлаж үг хэлэхийг зөвшөөрье. Лувсанжамц гишүүний микрофоныг өгье.

Г.Лувсанжамц: Оройн мэнд хүргэе. Энэ Засгийн газарт өгч байгаа чиглэл нь болохоор 2025 оны хөгжлийн төлөвлөгөө 4 жилийн Засгийн газарт хөтөлбөр дээр тусгасан саналыг нь 2025 ондоо багтаагаад яг хэрэгжүүлэх зорилготойгоор оруулж байгаа санал байгаа. Хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч ААН-ийн саналыг тусгая гэдэг нь одоогийн хуулиараа байхгүй байгаа боловч 2025 онд хэд хэдэн аймгийн төвийн хот төлөвлөлтийн бичиг баримтууд хийгдэх гэж байгаа. Тэрэн дээр нь иргэд ААН-ийн саналыг аваад эхний ээлжид хийгээд эхэлчхээрэй гэдэг тийм агуулгатай заалт байгаа юм шүү. Дэмжиж өгөхийг хүсэж байна аа.

Р.Сэддорж: Саяын томьёолсон томьёоллоор санал хураалт явуулъя аа. 64.3 хувиар санал дэмжигдлээ.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх.

4.Барилгын салбарт шинэ инновацлаг бараа материал угсралтын арга барилыг хурдацтай нэвтрүүлэх зорилгоор хот байгуулалт, зураг төсөл, барилгын ажлын стандарт, норм дүрмийг боловсронгуй болгох ажлыг Барилга байгууламжийн норм нормативын сангийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц саналаа тайлбарлая. Лувсанжамц гишүүн гишүүний микрофоныг өгье.

Г.Лувсанжамц: Одоо манай хуулиар Барилгын хөгжлийн төв энэ барилгын норм ба дүрэм стандартыг боловсруулж байгаа боловч ААН-ийн саналыг сонсохоор ийм шинэлэг аргачлал шинэлэг материалуудыг яаж ашиглах юм бэ гэдгийг нь оруулаад ирэхээр тэрийг нь нэвтрүүлэх ажил нь ингээд удаад байгаа юм байна лээ. Тэгэхээр ингээд манай барилгын салбар ингээд нөгөө ур чадвартай ажилчид нь гадагшаагаа явчих гээд уг нь Монголдоо хэрвээ энэ норм стандарт нь байгаад бүрэн хэрэгждэг болоод эхлэх юм бол одоо хэрэгжүүлэх гэж байгаа 14 мега төсөл дээр ч гэсэн уг нь хэрэгтэй зүйл байгаа учраас тэрэндээ бэлдэх зорилгоор 2025 ондоо багтаад төсөв дээр мөнгө нэмэхгүйгээр одоо байгаа норм нормативын сангийн санхүүжилтийн хүрээнд шинэчлээч гэсэн ийм агуулгатай санал гаргасан юм аа. Дэмжиж өгөхийг хүсэж байна аа.

Р.Сэддорж: Уг томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Лувсанжамц гишүүний 2 санал хоёулаа дэмжигдлээ. 64.3 хувиар санал дэмжигдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Маргааш бас Төсвийн байнгын хороон дээр сая асууж амжаагүй хүмүүс Төсвийн байнгын хороон дээр асуулт асууж болно. Миний хувьд бас энэ төрийн өмчийн хорооноос асуулт асуух бодолтой байсан. Маргаашаас асууя.

Хууль тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн

*Ренчиндоржийн Батболд Төсвийн
байнгын хорооны хуралд танилцуулна аа.*

*Хуралдаанд идэвхтэй оролцсон
гишүүддээ баярлалаа. баярлалаа.*

*Эдийн засгийн байнгын хорооны
өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж,
хуралдаан үүгээр өндөрлөж байна.*

19.16 цагт

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*